

Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

НӨӨЦИЙН МАХ БЭЛТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН



Махны нөөцийн талаарх бодлогын хэрэгжилт зорилтот хэмжээндээ хүрээгүй байна

АГУУЛГА	Товчилсон үгс	2
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Оршил	4-6
УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Б.Баттуяа	Бүлэг 1. Хүн амыг хэрэгцээт мах, махан бүтээгдэхүүнээр хангах, мах нөөцлөлтийн талаар төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилт зорилтот хэмжээнд хүрээгүй байна	7-11
Хэлтсийн захирал-менежер Г.Гүнжидмаа		
Ахлах аудитор У.Баярмаа		
Аудитор Б.Нямхүү	Эрх зүйн баримт бичгүүдэд тусгасан зарим арга хэмжээний хэрэгжилт зорилтот хэмжээндээ хүрээгүй байна	7-10
Нийслэлийн аудитын газрын Аудитын менежер Х.Баасандорж	Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээнд олон нийт сэтгэл дундуур байна	10-11
Ахлах шинжээч З.Болд		
Аудитор Ё. Лхагвадулам		
Шинжээч: Д. Ичин	Бүлэг 2. Гэрээний зарим заалтыг зөрчсөн ч хариуцлага тооцоогүй байна	12-18
Дархан-Уул аймгийн аудитын газрын	Нөөц бүрдүүлэх хувь хэмжээнд өөрчлөлт оруулсан ч бэлтгэсэн мах гэрээт хугацаанд бүрэн борлогдоогүй байна	12-13
Аудитын менежер Ц.Отгонсүх		
Ахлах аудитор Г.Цогтбаатар		
Аудитор Ө.Аагч-Энхтүвшин		
Аудитор Х.Сувдмаа	Сертификатыг үндэслэлгүй зээл олгож, зориулалтын дагуу ашиглаагүйд Монголбанк хяналт тавиагүй байна	13-15
Орхон аймгийн аудитын газрын	Хадгалалтын явцад ажлын байрны нөхцөл, хөдөлмөр аюулгүй ажиллагааг сайжруулах шаардлагатай байна	16
Ерөнхий аудитор Д.Цогбадрах		
Аудитын менежер Б.Байгал		
Аудитор Б.Мядагмаа		
Шинжээч Т.Болормаа	Ангилан савлахад доголдол гарч байжээ	16
2013 оны 11 дүгээр сар	Бэлтгэсэн нөөцийн махны ангилан савласны болон хорогдлын зардлыг илүү санхүүжүүлжээ	17-19
Уг тайланг УАГ-ын Вэб сайт-аас үзнэ үү.		
www.mnao.mn	Бүлэг 3. Хүн амыг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махаар тогтвортой хангах бодлого үгүүлэгдэж байна	20-22
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлыг 263806, 262451 дугаарын утас болон 323266 дугаарын факсаар харилцаж тодруулна уу.	Зөрчлийн дийлэнх нь бэлтгэл, борлуулалтын үед гарчээ	20-21
ХАЯГ:	Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махаар хангах шаардлагатай байна	21-22
Үндэсний аудитын газар		23
Чингэлтэй дүүрэг,		
Бага тойруу-3,		
Засгийн газрын IY байр		
Улаанбаатар хот 15160	Дүгнэлт	24
	Зөвлөмж	

Товчилсон үг

ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НХЭАХН	Нийслэлийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
тн	тонн
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХАА	Үйлдвэр, хөдөө аж ахуй
ҮХААС	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудитор Түндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Түндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Нөөцийн мах бэлтгэн, нөөцөлж борлуулах үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийлээ. Үүнд:

- Нөөцийн мах бэлтгэх талаар төрөөс баримталж буй бодлого, зорилтын хэрэгжилт, зохицуулалт хангагдаж байгаа эсэх.
- Нөөцийн мах бэлтгэх, хадгалах, борлуулах үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнтэй эсэх
- Нөөцийн мах бэлтгэх ажил улс, орон нутаг, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх

Аудитад нөөцийн мах бэлтгэх, нөөцөлж хадгалах, худалдан борлуулах үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлж, хяналт тавьж буй ҮХААЯ, Монголбанк, Нийслэлийн болон Дархан-Уул, Орхон аймгийн ИТХ, ЗДТГ-ын холбогдох газар, хэлтэс, захирагчийн ажлын алба, ОБЕГ, МХЕГ, ШӨХТГ, Нөөцийн махны менежер Жаст-Агро, Баатарууд тэнгэр, Эрдмийт компаниуд, Монголын Махны Холбоо, НХЭАХН, Эрүүл мэнд аюулгүй байдал болон Хүнс Эвсэл төрийн бус байгууллагууд хамрагдлаа.

Аудитыг ҮАГ, Нийслэлийн болон Дархан-Уул, Орхон аймгийн аудитын газрын аудитор, шинжээч, арга зүйч нар гүйцэтгэлээ.


Аудитын арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг баримтлан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал асуулга авах, лавлагаа гаргуулан, шалгуурыг бодит байдалтай харьцуулан, судалгааны материалд шинжилгээ хийж, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

ОРШИЛ

Манай улсын малын тоо 2012 оны тооллогоор 40.9 сая толгойд хүрч өмнөх оныхоос 11.2 хувиар өсчээ.

Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт, тэрбум төгрөгөөр




Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эзлэх мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт 2010-2012 онуудад тогтмол нэмэгдсэн байна.

Мал сүргийн тоо, хэмжээ /сая толгой/



Манай улсын малын толгой болон хүнсэнд хэрэглэсэн малын тоо 2010 оноос жил бүр өссөөр ирсэн бөгөөд жилд дунджаар 8.0 сая гаруй толгой мал хүнсэнд хэрэглэж 200 орчим мян.тн мах үйлдвэрлэн дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж иржээ.

2012 онд улсын хэмжээгээр хүнсэнд хэрэглэсэн малын бүтэц



Улсын хэмжээгээр 2012 онд нийт 8.3 сая толгой мал хүнсэнд хэрэглэхээр бэлтгэсний 44.0 хувийг хонь, 47.2 хувийг ямаа, 5.6 хувийг үхэр, 2.9 хувийг адуу, 0.3 хувийг тэмээ эзэлж байжээ.

Сүргийн бүтцээрх нядлах боломжит малын тоо, хүнсэнд хэрэглэж буй үхэр, хонь, ямааны харьцаа 2012 оны хувьд алдагдсан, тухайлбал, үхрийн нядлах боломжит хувь 14.0 байхад оны эхний малын тоонд харьцуулсан хэрэглээнд зарцуулсан хувь нь 20.1, хониных 21.2 байхад 23.5, ямааных 25.8 байхад 24.8 хувь байна.

2012 онд хэрэглээнд зарцуулах боломжит болон зарцуулсан мал мян.толгой

	Хэрэглээнд зарцуулсан мал		Нядлах боломжит мал	
	тоо	оны эхний малд эзлэх хувь	тоо	оны эхний малд эзлэх хувь
бүгд	8,365.0	23.0	9,525.0	23.3
Адуу	238.3	11.3	710.6	30.5
үхэр	469.9	20.1	363.0	14.0
тэмээ	25.2	9.0	76.2	24.9
хонь	3,679.6	23.5	3,851.3	21.2
ямаа	3,952.0	24.8	4,523.8	25.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Жил бүрийн хавар махны хомсдол үүсч үнэ өсдгийг зохицуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газар 2006-2012 онд Нийслэл болон томоохон хотуудын хүн амын хавар зуны хэрэгцээнд зориулан тодорхой хэмжээний мах бэлтгэн нөөцөлж, тогтоосон үнээр борлуулах арга хэмжээг авч иржээ. Ингэхдээ Монголын махны холбооны оролцоотойгоор махны нөөцийг бүрдүүлэх компаниудыг сонгон шалгаруулж, тоо хэмжээг хуваарилан борлуулах үйл ажиллагааг зохион байгуулсан байна.


АНУ-ын USAID байгууллагын хэрэгжүүлж буй Эдийн засгийн Шинэчлэл, Өрсөлдөх Чадвар EPRC төслөөс 2010 онд хийсэн Монголын махны зах зээлийн судалгаагаар Засгийн газрын улсын нөөцийн мах бүрдүүлэх тогтолцооны үр нөлөөг дараах байдлаар үнэлжээ.

Энэхүү мах нөөцлөх үйл ажиллагаа нь үндсэн зорилтуудаа биелүүлж чадаж буй эсэх нь тодорхойгүй байна.


- *Нэгдүгээрт, нөөцийн махны чанар нь дунджаас доогуур байдаг бөгөөд хавар болон зуны эхэн улиралд гаргаж буй мах нь нийт хүн ардад бодитой ашиг тусаа өгч буй эсэх нь маргаантай байна.*
- *Хоёрдугаарт, хэрвээ хувийн секторынхонд мах нөөцлөх элементүүд нь байгаа юм бол зах зээл нь өөрөө тэдэнд ингэх шаардлагыг нь гаргаж өгөх ёстой, харин Засгийн Газрын оролцоо шаардлагатай эсэх нь асуудалтай байна.*
- *Гуравдугаарт, нийлүүлэгчдэд олгож буй татаас нь үр дүнтэй байгаа нь харагдахгүй байна, үүнд юуны түрүүнд махны нөөц бэлтгэх компаниудыг сонгох механизм нь ойлгомжгүй ... Хамгийн гол нь, энэ нь хуйвалдаан хийх ажиллагааг дэмжсэн механизм мэт санагдаж байна .*

Итали Улсын Засгийн газрын “Итгэлцлийн сан”-гийн буцалтгүй тусламжаар НҮБ-ын ХХААБ, ХХААХҮЯ /хуучнаар/ хамтран хэрэгжүүлсэн “Махны чанар, аюулгүй байдлыг сайжруулах” төслөөс 2012 онд хийсэн махны өртөг, зах зээлийн судалгаагаар махны хэрэглээ, үнийн талаар санал асуулгад оролцогсод дараах хариулт өгчээ. Үүнд:

Хэрэглэгчдийн 28.2-43.6 хувь нь гол төлөв шулсан болон ястай нь мөчилсөн мах худалдан авдаг байна.



Ямар малын махыг илүү түлхүү хэрэглэдэг вэ?



Сүүлийн жилүүдэд үхрийн махны хэрэглээ байнга өсч ямааны махыг уламжлалын дагуу бага хэрэглэж байна.

Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүний бэлтгэл, борлуулалт “малчид-ченж-бөөний худалдаачин-зах, дэлгүүр-хэрэглэгч” гэсэн дамжлага бүрт кг тутамд 200-500, дүнгээрээ 1300-2000 төгрөгөөр нэмэгддэгийн зэрэгцээ хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал зөрчигддөг байна.



Санал асуулгад оролцогсдын 84.2 хувь нь мах, махан бүтээгдэхүүний үнийг өндөр, 13.9 хувь нь боломжийн, 1.8 хувь нь хямд гэж хариулжээ.

БҮЛЭГ 1

Хүн амыг хэрэгцээт мах, махан бүтээгдэхүүнээр хангах, мах нөөцлөлтийн талаар төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилт зорилтот хэмжээнд хүрээгүй байна

Эрх зүйн баримт бичгүүдэд тусгасан зарим арга хэмжээний хэрэгжилт зорилтот хэмжээндээ хүрээгүй байна

“Хүнсний тухай хууль”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-д монгол хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилт, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг эрүүл мэндийн, хүнсний хангамжийг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд тодорхойлж, хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах, стратегийн хүнсний бүтээгдэхүүний улирлын нөөц бүрдүүлэх журмыг Засгийн газраас батлахаар заажээ.

Дараах эрх зүйн баримт бичигт хүн амын махны хэрэгцээ, хангамжийн талаар тусгасан байна.Үүнд:

Улсын Их Хурлын тогтоол:

- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай, 2003 оны 29 дүгээр,
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай, 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 37 дугаар,
- МУЗГ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар,
- Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай, 2012 оны 57 дугаар,
- Хүнсний тухай хууль болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай, 2012 оны 67 дугаар.


Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- Хүнсний аюулгүй байдал үндэсний хөтөлбөр батлах тухай, 2009 оны 32 дугаар,
- Ажлын хэсэг байгуулах тухай, 2012 оны 104 дүгээр,
- Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай, 2012 оны 120 дугаар,
- Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл байгуулах тухай, 2013 оны 78 дугаар.

Мөн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үндэс, мал аж ахуйн талаар авах арга хэмжээ, үүний дотор эрчимжсэн аж ахуйг нэмэгдүүлэх, хөгжүүлэх зорилтуудыг Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр /ЗГ-ын 2003 оны 160 дугаар тогтоол/, Монгол мал үндэсний хөтөлбөр /УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоол/-үүдэд тусгасан байна.

Хүн амын махны хэрэгцээ, хангамжийн талаар эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдсан зарим арга хэмжээний хэрэгжилт зорилтот хэмжээндээ хүрээгүй байна. Тухайлбал:

- ✚ Хүнсний аюулгүй байдал хөтөлбөрт зааснаар хүн амын хэрэгцээт махыг 100 хувь дотоод эх үүсвэрээр хангасан хэдий ч 2012 онд үйлдвэрийн аргаар 15.4 мян.тн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бөгөөд 50.0 мян.тн-ыг бэлтгэх зорилт бүрэн хангагдаагүй,
- ✚ Махны үйлдвэрлэлийн хэмжээ 2012 онд 28.3 хувиар өссөн ч 2007 оноос 35 хувиар нэмэгдүүлэх зорилтот хэмжээнд хүрээгүй,
- ✚ Засгийн газрын 2013 оны 78 дугаар тогтоолын дагуу Хүнсний тухай болон Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэгтэй “Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл”-ийн үйл ажиллагаа эхлэл төдий,

- 
 ҮХАА-н салбар хаврын улирлын махны үнийн өсөлтийг өмнөх оны мөн үеийнхээс 2 дахин бууруулах тэргүүлэх зорилт тавьсан нь хангагдаагүй, 2013 оны эхний зургаан сарын байдлаар нэг кг махны худалдах сар бүрийн дундаж үнийн өсөлт хониных 35.5-87.2, үхрийнх 27.9-88.4 хувийн бууралттай байна.

1 кг ястай махны жижиглэн худалдах дундаж үнийн өсөлт 2011-2013 он, хувиар

Сарууд	Үхрийн мах		өөрчлөлт	Хонины мах		өөрчлөлт
	2011/ 2012 он	2013/ 2012 он		2012/ 2011 он	2013/ 2012 он	
1-р	13.1	41.0	3.1 дахин	18.6	39.6	2.1 дахин
2-р	38.9	25.1	-35.5	39.0	28.1	-27.9
3-р	67.2	15.5	-76.9	84.4	9.8	-88.4
4-р	80.3	15.7	-80.4	94.5	14.2	-85.0
5-р	66.2	14.7	-77.7	75.2	13.3	-82.3
6-р	70.9	9.0*	87.2	77.7	13.9*	-82.1

*1-р долоо хоногийн ажиглалтаар Эх сурвалж: Нийслэлийн статистикийн газар

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлд “Мөнгөний бодлогын арга хэрэгслээр инфляцыг тогтвортой нам түвшинд байлгаж, Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг хязгаарлах бодлого баримталсны дүнд ХҮИ-ээр хэмжигдэх инфляцийг оны эцэст найман хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгах... нөхцөл бүрдүүлнэ” гэжээ.

Хэрэглээний үнийн улсын индекс 2013 оны 5 дугаар сарын эцэст 9.7, Улаанбаатар хотынх 8.4 хувь байгаа нь дээрх түвшингээс өндөр байна.

	Улаанбаатар				Улс		
	Сарын	Оны эхнээс	Жилийн	Суурь /Жилийн	Сарын	Оны эхнээс	Жилийн
2013 / 05	0.3	3.9	8.4	7.6	0.3	5.1	9.7
2013 / 04	0.7	4.3	9.8	9.3	1.1	4.8	10.4
2013 / 03	0.8	3.6	9.4	9.2	0.8	3.6	9.8
2013 / 02	1.1	2.7	11.1	8.7	1.0	2.8	11.3
2013 / 01	1.5	1.5	12.7	9.6	1.8	1.8	13.0

Эх сурвалж: Монголбанк

Инфляци өмнөх оны мөн үеэс буурсан хэдий ч 2013 оны 3 дугаар сард инфляцид үзүүлэх махны үнийн нөлөөлөл 18.6 хувь байсан нь 5 дугаар сард 22.6 болж 4 пунктээр буюу 21.5 хувиар өссөн нь Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлж буй ХҮИ-ээр хэмжигдэх инфляцийг нам түвшинд байлгах зорилт хангагдаагүйг харуулж байна.

Огноо сараар	Махнаас бусад хүнс	Мах	инфляцид махны нөлөөллийн эзлэх хувь	Шата-хуун	Төрийн зохицуулалттай бараа	Бусад /эргэлтийн гаралтай инфляци/	Инфляци
2010-3	0.9	3.0	38.5	0.2	0.6	3.1	7.8
6	-0.2	8.1	64.3	0.5	1.1	3.1	12.6
2011-3	1.1	0.5	8.2	0.1	1.5	3.0	6.1
6	1.2	-2.8	-	0.6	1.8	1.8	2.65
2012-3	1.2	7.4	42.8	0.9	1.5	6.3	17.3
6	0.7	7.4	49.0	0.2	0.9	5.8	15.1
2013-3	1.41	1.74	18.6	0.13	0.39	5.69	9.35
5	1.5	1.9	22.6	0.24	0.38	4.39	8.41

Эх сурвалж: Монголбанк

Засгийн газраас махны ханган нийлүүлэлтийг сайжруулахаар баталсан “Загас” дэд хөтөлбөр, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд загас, гахай, тахианы аж ахуйг дэмжих, өндөр ашиг шимтэй махны чиглэлийн

үржлийн өсвөр үхрийг импортлон цогцолбор аж ахуйг байгуулах, дотоодын зах зээлийг махны чиглэлийн хээлтэгч, хээлтүүлэгч, үрээр хангах зэрэг арга хэмжээний хэрэгжилт эхлэлийн байдалтай, үр дүн нь гарах болоогүй байна.

“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн нийт санхүүжилтийн 13.3, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн нийт санхүүжилтийн 0.8 хувийг гахай, тахиа шувууны аж ахуйн хөрөнгө оруулалтад олгохоор байгаа нь харьцангуй бага хэмжээ юм.

Мөн 2011 онд батлагдсан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах тээвэрлэх харилцааг зохицуулах “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн хэрэгжилт, тухайлбал малыг биржээр арилжаалах ажил хангалтгүй байна.

ХХААХҮС-ын 2011 оны А/74 дүгээр тушаалаар баталсан “Малыг бүртгэх мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх” журмын дагуу төсвийн хөрөнгөөр нийслэл болон 21 аймгийн 330 сумын бүртгэл хариуцсан мэргэжилтнийг сургалтад хамруулж, компьютер олгон програмаар хангасан ба 121 сумыг интернэтийн сүлжээнд холбож малын бүртгэлийн мэдээллийн сантай болсон байна.

Гэтэл мэдээллийн санд байвал зохих суурь үзүүлэлтүүд тухайлбал, хүн амын махны хэрэгцээ, хэрэглээ, малын тооны өсөлт, сүргийн бүтэц, түүнд эзлэх нядлах боломжит малын хувийн жин, шилжилт хөдөлгөөн, мөн эрчимжсэн аж ахуйн чиглэлээрх малын тоо, хэрэглээний зарлага, түүнчлэн малын хавар, намрын амьдын болон нядалгааны жин, боловсруулах үйлдвэр, цех, түүнд нийлүүлсэн малын тоо зэрэг ашиг шимийн болон үнийн мэдээлэл өнөөг хүртэл бүртгэгдээгүй байна.

Энэ нь махны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, малын гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хянах боломжгүй болгож байгаа бөгөөд энэ талаар мөрдөж буй бодлогын баримт бичиг ҮХААЯ-нд алга байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр нь Хүнсний тухай болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд аймаг, нийслэлийн болон тухайн шатны Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах, хангамжийг сайжруулахад орон нутгийн нөөц бололцоог илрүүлж ашиглах ажлыг зохион байгуулах, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэхээр заасантай нийцэхгүй байна.

Мөн ҮХААС-ын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2013 онд байгуулсан гэрээнд Засаг дарга нь нутаг дэвсгэрийн хүн амын хүнсний хангамж, махны нөөц бүрдүүлэхэд анхаарч ажиллах, үхэр, хонь бордох эрчимжсэн цогцолбор аж ахуй байгуулан зах зээлд шинэ мах жилийн турш нийлүүлэх, стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч, орон нутгийн хүн амын мах, сүү, төмс, хүнсний ногооны хэрэгцээг чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр бүрэн, тогтвортой, хүртээмжтэй хангах үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хүнсний аюулгүй байдал, хангамжийн статистикийн үзүүлэлтийг болон өрхийн хэрэглээний сагсыг тооцох ҮСХ-ны даргын 2008 оны 01/176 дугаар тушаалаар баталсан аргачлал, ЭМС-ын 2008 оны 257 дугаар тушаалаар хүн амын хоол тэжээлийн физиологийн нормоор жишсэн дундаж нэг хүний хоногийн мах, махан

бүтээгдэхүүний хэрэглээг 175 гр, жилд 63.9 кг байхаар баталснаар хүн амын махны хэрэгцээг тооцож байна.

Хүнсний аюулгүй байдал төслийн судалгаагаар 2012 онд хот суурин газрын нэг хүн өдөрт 222 гр, хөдөөд 335 гр, улсын хэмжээгээр 181.5 мян.тн мах хүнсэнд хэрэглэсэн дүн гарчээ.

Улаанбаатар хотын 2013 оны хаврын хэрэгцээнд зориулж дээрх нормоор тооцож 14.0 мян.тн нөөцийн мах бэлтгэхээр төлөвлөснөөс 9.4 мян.тн-ыг буюу 67.1 хувийг бэлтгэсэн ч гэрээт хугацаандаа бүрэн борлогдоогүйгээс үзэхэд хэрэглээний нормыг нягтлах шаардлагатайг харуулж байна.

ҮСХ-ны Хүнсний аюулгүй байдал, хангамжийн статистикийн үзүүлэлт болон өрхийн хэрэглээний сагсыг тооцох аргачлалаар зах зээл дэх махны үнийн түүвэр судалгааг хийхдээ дараах нөлөөллийг харгалздаггүй байна.Үүнд:

- + өвөл, хаврын улиралд хүн амын 70-80 хувь нь хөлдүү мах хүнсэнд хэрэглэдэг байхад тогтмол шинэ, нойтон махны үнээр мэдээлдэг,
- + дараах захуудад харилцан адилгүй хэмжээ, өөр өөр үнээр мах борлогддог байхад үнийг жигнэсэн бус арифметик дунджаар тооцон судалгаа, мэдээнд ашигладаг. Хүснэгтээс харна уу.

Махны жижиглэн худалдах дундаж үнэ, 2013 оны 6-р сар 1-р долоо хоног /төгрөгөөр/

д/д	Хүнсний захууд	Нэг өдрийн борлуулалтын дундаж хувь*	Үхрийн		Хонины		Ямааны	Адууны
			ястай	цул	ястай	цул	ястай	ястай
1	Баянзүрх		8100	9500	7400	8000	6400	7000
2	Хүчит шонхор	70-80	8000	9500	7200	7800	6200	6500
3	Бөмбөгөр		9500	11000	8500			7000
4	Меркури	1-3	10000	11500	9800			
5	Барс		8000	9500	7400			7000
6	Таван эрдэнэ		10500	11500	9500			
7	Хар хорин		8300	9500	7400	8200	6200	
8	Марко супермаркет							7000
	Дундаж		8914	10286	8171	8000	6267	6900

Эх сурвалж: Нийслэлийн статистикийн газар *ҮХААЯ-ны судалгаагаар

Ийнхүү дээрх нөлөөллийг харгалзалгүй гаргасан үнийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан, өрхийн хэрэглээний сагс, инфляцийн түвшинг тооцоход ашигладаг нь махны үнийг хөөрөгдөх, хэрэглэгчдийг төөрөгдүүлэх, цаашилбал эдийн засгийн үзүүлэлт ташаа болох нөхцлийг бүрдүүлж байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээнд олон нийт сэтгэл дундуур байна

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 47 дугаар тэмдэглэлд хүн амын 2013 оны хаврын хэрэгцээнд зориулан 16.0 мян.тн мах бэлтгэн нөөцлөх, худалдан борлуулах ажлыг хариуцан зохион байгуулахыг ҮХААС, урамшуулалд зориулан 16.0 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд нарт даалгасан бөгөөд урамшуулалд олгох мөнгө нь 2013 оны ҮХААС-ын төсвийн багцын татаас шилжүүлгийн зардалд батлагдсан байна.

Мөн нөөцийн махны урамшууллын хэмжээг тогтоох тухай ҮХААС-ын 2013 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/52, Сангийн болон ҮХААС-ын 2013 оны 5 дугаар

сарын 15-ны өдрийн 100/А70 дугаар тушаалаар 2013 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан бэлтгэн нөөцөлж худалдан борлуулсан махны нэг килограмм тутамд олгох урамшууллыг 1000 төгрөгөөр тогтоож аж ахуйн нэгжүүдэд олгох, түүнд хяналт тавьж ажиллахыг ҮХААЯ-ны Стратеги бодлого төлөвлөлтийн газар, СЯ-ны Төсвийн бодлого төлөвлөлтийн газарт тус тус даалгажээ.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд инфляцыг нам, тогтвортой түвшинд байлгах зорилтыг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Монголбанк тохиролцож 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт 2012 оны 12 дугаар сарын 22, 2013 оны 5 дугаар сарын 15-ны өдөр тус тус өөрчлөлт оруулсан ба Монголбанкны Ерөнхийлөгч, ҮХААС-ын 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-166/А/24 дугаар тушаалаар “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг /цаашид Дэд хөтөлбөр гэх/ батлан хэрэгжүүлсэн байна.

Хамтран хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн нэг болох “Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрт 3 жилийн хугацаанд Монголбанкнаас зээлийн шугам нээх, санхүүгийн үүсмэл хэрэгслийг ашиглан мах бэлтгэн нийлүүлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгож, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах замаар махны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах нөхцлийг тогтмол хангах зорилт дэвшүүлж, хөтөлбөрийн хүрээнд:

- ✚ Махны чиглэлийн аж ахуй үүсгэн байгуулах сонирхлыг бий болгох,
- ✚ Дотоодын зах зээл дэх махны нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах,
- ✚ Улсын махны зоорьтой болох,
- ✚ Мал сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэх,
- ✚ Мал нядалгааны цэгүүдийг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах хөтөлбөрийн 2.2.1-д “*Нөөцийн махны менежерт зоорин дахь махны нөөцөө барьцаанд тооцуулан хөнгөлөлттэй зээл авах боломжийг олгоно.*”, 2.4-т “*Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах*” хөтөлбөрт нийт 87.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн шугам нээнэ.” гэж тусган Монголбанк 14, ҮХААЯ 19 чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна.

Мах бэлтгэн нөөцөлж борлуулах үйл ажиллагаанд төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийн талаар Дархан-Уул, Орхон аймаг, Нийслэлийн 9 дүүргийн 1175 хэрэглэгчээс авсан судалгаа, санал асуулгад оролцогсдын 29.4 хувь маш сайн, сайн, 34.9 хувь дунд зэрэг, 35.7 хувь тааруухан, маш муу гэж үнэлжээ.

Мөн зах зээлд махны үнэ буурахгүй байгаагийн шалтгааныг төрийн бодлого, зохицуулалт дутагдалтай гэж оролцогсдын 27.8 хувь, бодлого, зохицуулалт байгаа ч хэрэгжилт хангалтгүй гэж 13.7 хувь, махны ченж, бэлтгэн нийлүүлэгч компаниудын хуйвалдаантай холбоотой гэж 22.2 хувь нь үзсэн байна.

БҮЛЭГ 2

Гэрээний зарим заалтыг зөрчсөн ч хариуцлага тооцоогүй байна

Нөөц бүрдүүлэх хувь хэмжээнд өөрчлөлт оруулсан ч бэлтгэсэн мах гэрээт хугацаанд бүрэн борлогдоогүй байна

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд ҮХААЯ-наас 2012 оны 10 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 5-ны өдөр Монголын Махны болон Монголын түүхий эд бэлтгэгчдийн холбоо төрийн бус байгууллага, махны үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 10 аж ахуйн нэгжид нөөцийн махны менежерээр ажиллах, мах хадгалахад зоорио түрээслэх хүсэлтээ ирүүлэх албан бичгийг хүргүүлснээс Улаанбаатар хотод 15, Дархан хотод нэг, Эрдэнэт хотод 3 аж ахуйн нэгж оролцох саналаа ирүүлжээ.

ҮХААЯ-ны ТНБД-ын 2012 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар батлагдсан “Нөөцийн махны менежер”-ийг сонгон шалгаруулах ажлын хэсэг Улаанбаатар хотод Жаст-Агро ХХК-ийг 14.0 мян.тн, Дархан хотод Баатарууд тэнгэр ХХК-ийг, Эрдэнэт хотод Эрдмийт ХХК-ийг тус бүр 1.0 мян.тн махны нөөц бүрдүүлэхээр шалгаруулж 2012 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/06 дугаар тушаалаар гэрээ байгуулах эрх олгосон байна.

ҮХААЯ, ОБЕГ, МХЕГ, гүйцэтгэгчийн нөөцийн махны менежментийн 127, 128, 129 дүгээр 3 талт гэрээг 2013 оны 8 дугаар сарын 31-нийг дуусталх хугацаанд хүчинтэйгээр 2012 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр байгуулжээ.

Жаст-Агро ХХК-ийн гэрээний хэрэгжилтийн явцын тайлан, хүсэлтийг хэлэлцээд 2013 оны 2 дугаар сарын 6, 5 дугаар сарын 27-ны өдөр гүйцэтгэгчтэй байгуулсан 129 дүгээр гэрээнд дараах нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна. Үүнд:

	Гэрээнд зааснаар	Шинээр нэмсэн, өөрчлөлт оруулснаар
3.7	нөөцийн мах бүрэн төвлөрүүлэх хугацаа	
	2013 оны 2 дугаар сарын 10-ны өдөр	2013 оны 7 дугаар сарын 1-ний өдөр
	Улсын нөөцөд бүрдүүлэх	
3.9	үхрийн махны хэмжээ 15 хувиас доошгүй, ямааны махны хэмжээ 35 хувиас ихгүй	үхрийн махны хэмжээг 12 хувиас доошгүй, ямааны махны хэмжээ 50 хувиас ихгүй байна.
5.5	“төлбөрийн 50 хувийг гэрээний 3.7-д заасан хугацааны дараа” гэсэн хэсгийг	2013 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн сертификатаар баталгаажсан махны бодит гүйцэтгэлийн дүнгээр
5.6		2013 оны 2 дугаар сарын 20-ны өдрөөс хойш шинээр нэмж төвлөрүүлэх нөөцийн махны хувьд 5.2-т заасан бүх зардлыг нөөцийн махыг жижиглэн худалдаанд нийлүүлж дууссаны дараа гэрээ дүгнэсэн актыг үндэслэн гүйцэтгэгчид шилжүүлнэ
7.3	гэрээний үнийн дүнгийн	Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн
3.15		Нөөцийн махыг гэрээний хугацаанд дотоодын зах зээлээс бүрдүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсвэл мах импортлон төвлөрүүлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх
3.16		Нөөцийн махыг жижиглэн борлуулах дэлгүүр захын байршлыг баталгаажуулж, махыг ваучераар борлуулах, хяналт тавих схемийг боловсруулан 2013 оны 2 дугаар сарын 20-ны дотор захиалагчаар батлуулах
1.1	Улаанбаатар хотод 14000 тн	9421 тн
3.17		Нэмж махны нөөц бүрдүүлэх зорилгоор байршуулсан мөнгийг 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор Монголбанкнд буцаан төвлөрүүлэх

Мөн ОБЕГ, ҮХААЯ, МХЕГ, ШӨХТГ, НХЭАХН, Монголын Махны Холбоо зэрэг байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг нийслэлд нөөцийн мах хадгалах, жижиглэн савлаж түгээх үүрэг бүхий зоорины менежер 9 аж ахуйн нэгжийг сонгосон нь нөөцийн махны менежер Жаст-Агро ХХК-тай гэрээ байгуулан ажиллажээ.

Нийслэлийн Захирагчийн Ажлын алба, дүүргүүдийн Худалдаа, үйлчилгээний хэлтсүүд нийслэлийн хүн амын 2013 оны хаврын улирлын махны хангамж, “Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зөвхөн бэлтгэсэн нөөцийн махыг борлуулах 358 дэлгүүрийн судалгааг гаргаж батлах ажлыг зохион байгуулсан байна.

Нийслэл, томоохон хотуудын хүн амын 2013 оны хаврын хэрэгцээнд 11.4 мян.тн нөөцийн мах бэлтгэсний 22.5 хувийг үхрийн, 39.3 хувийг хонины, 38.2 хувийг ямааны мах эзэлж байгаа нь менежментийн гэрээний нэмэлт өөрчлөлтөд заасан хувь хэмжээг хангасан байна.

Аймаг, нийслэл	Нөөцийн махны менежер аж ахуйн нэгж	Бэлтгэсэн махны хэмжээ, тн-р						Нийт
		Үхрийн		Хонины		Ямааны		
		тоо	Эзлэх хувь	тоо	Эзлэх хувь	тоо	Эзлэх хувь	
Улаанбаатар	Жаст-Агро	1 455.3	15.4	3 871.0	41.1	4 094.7	43.5	9 421.0
Дархан-уул	Баатарууд тэнгэр	570.1	57.0	327.9	32.8	102.0	10.2	1 000.0
Орхон	Эрдмийт	546.1	54.6	291.2	29.1	162.7	16.3	1 000.0
	Бүгд	2 571.5	22.5	4 490.1	39.3	4 359.4	38.2	11 421.0

Гэвч нийслэлд Жаст-Агро ХХК 2013 оны 7 дугаар сарын 25-нд Хадгаламж банк ХХК-ийн эрх хүлээн авагчид хүлээлгэн өгсөн борлогдоогүй үлдсэн махны 76.2 хувийг ямааны мах эзэлж байгаа нь харьцангуй их бэлтгэснийг харуулж байна.

Нийслэлийн хүн амын хаврын хэрэгцээний махны 37.6 хувийг бэлтгэхээр төлөвлөснөөс 12.3 хувиар дутуу бэлтгэсэнд тооцох хариуцлагын заалт гэрээнд алга байна.

Сертификатыг үндэслэлгүй зээл олгож, зориулалтын дагуу ашиглаагүйд Монголбанк хяналт тавиагүй байна

Дэд хөтөлбөрийг үндэслэн Монголбанкт байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу нөөц бүрдүүлэх, махны худалдан борлуулах үнээр тооцож Хадгаламж банкинд 76.1, ХААН, Худалдаа хөгжлийн банкинд тус бүр 5.45, нийт 87.0 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх эх үүсвэрийн эрхийг 2012 оны 11 дүгээр сарын 11-нээс 12 дугаар сарын 24-ний өдөр нээсэн байна.

Хадгаламж банк нь банкны зээлийн хорооны хурлын шийдвэр, зээлдэгчийн хүсэлтийг харгалзан Зээлийн шугам нээх гэрээнүүдийг 2012 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр байгуулснаар Жаст агро ХХК-д 2012 оны 11 дүгээр сарын 28-наас 2013 оны 1 дүгээр сарын 24-ний хооронд 25.37, Мах маркет ХХК-д 2012 оны 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 21-ний хооронд урьдчилгаа зээл болон сертификатаар 25.37, Эрдэнэт мах маркет ХХК-д 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдөр урьдчилгаагаар 25.37, нийт 76.1 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Зээлдүүлэгч Хадгаламж банк Зээлийн шугам нээх гэрээний зээлийн үндсэн нөхцлийн 2.3¹, Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Хадгаламж банк, Жаст Агро ХХК-ийн хооронд байгуулсан 12-1060/122 дугаартай гэрээний 2.1.3²-т заасныг мөрдөлгүй Жаст Агро ХХК-д нийт зээлийн 96.8 хувийг сертификатыг³ үндэслэлгүй олгосон байна.

Мөн Жаст Агро ХХК Зээлийн шугам нээх гэрээний 2.5⁴, Дэд хөтөлбөрийн 2.7.2⁵, Нөөцийн махны менежментийн гэрээний 3.6⁶-д заасныг тус тус зөрчиж зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй байна. Тухайлбал:

- Жаст ойл ХХК-ийн Хадгаламж банкин дахь 10210000374 дугаар дансанд 2013 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр 840.0 сая төгрөгийг шилжүүлж, 2013 оны 1 дүгээр сарын 24-нөөс 2 дугаар сарын 18-ны хооронд нийт 9 удаагийн шилжүүлгээр буцааж авсан,
- Жаст группийн Хадгаламж банкин дахь 10210000377 дугаар дансанд 24,921.0 сая төгрөгийг бэлэн болон бэлэн бусаар шилжүүлж 2013 оны 5 дугаар сарын 30-нд 20,771.7 сая төгрөгийг буцаан авсан байна.

Монголбанк, Дэд хөтөлбөрийн 2.6.4⁷, 3.7⁸-д заасны дагуу дээрх байдалд хяналт тавьж тухай бүр арга хэмжээ аваагүй байна.

Хөтөлбөрийн зээлийг оролцогч Хадгаламж банк 2013 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Монголбанкин дахь харилцах данснаасаа бүрэн төлсөн байна.

Жаст агро ХХК нөөцийн мах бэлтгэлийн үйл ажиллагааг 10 аймагт байршилтай өөрийн мах боловсруулах үйлдвэрүүд, Улаанбаатар хотын 2 дүүрэгт байрлах сүлжээ 12 мах боловсруулах үйлдвэрүүдээ түшиглэн нийт бэлтгэсэн махны 17 хувийг, үйлдвэргүй Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Дундговь, Завхан зэрэг аймгуудад Хадгаламж банкны сүлжээг ашиглан аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ хийн 32 хувийг, 51 хувийг мах бэлтгэлийн компаниуд, махны чөлөөт бизнес эрхлэгч-ченжүүд, малчин иргэдээс худалдан авч нөөцөлжээ.

Ингэхдээ ХХААС-ын 2001 оны А/43 дугаар тушаалаар батлагдсан “Махны хяналтын дүрэм”-ийн 1.2⁹, 13.1¹⁰, 14.2¹¹-т заасныг мөрдөөгүй, гар аргаар төхөөрч их

¹ “Зээлийг зээлдэгчийн худалдан авсан нөөцийн махны сертификатанд үндэслэн хэсэгчлэн зээлдэгчийн Хадгаламж банкны тусгай харилцах дансанд шилжүүлнэ”

² “Харилцагч талд зээлийг олгоходоо бэлтгэн нийлүүлэгчийн авч ирсэн нөөцийн махны сертификатод үндэслэн зээлийг олгож...”

³ Мах нийлүүлсэн этгээдийн оноосон нэр, махны үнэ, хэмжээ, төрөл, зэрэглэл гэх мэт бусад шаардлагатай мэдээллийг агуулсан, хяналт тавих эрх бүхий этгээд /МХЕГ, ОБЕГ, Нөөцийн махны менежер, мах тушаагч/-ийн гарын үсгээр баталгаажих серийн дугаар бүхий нөөцийн махны сертификатыг үнэт цаасны компаниар хэвлүүлсэн байна.

⁴ “...зориулалтаас өөрөөр ашиглахыг хориглоно.”

⁵ “зээлийг зөвхөн зориулалтын дагуу ашиглана”

⁶ “Оролцогч банкнаас авсан зээлийг зориулалтын дагуу ашиглаж, зөвхөн мах худалдан авч нөөц бүрдүүлэхэд зарцуулах үүрэг хүлээнэ”

⁷ “Оролцогч банкт байгуулсан гэрээндээ тогтмол хяналт тавьж, санхүүжилтийн нэгдсэн мэдээг сар тутам гаргаж нийтэд мэдээлнэ.”

⁸ “Оролцогч банкт байгуулсан гэрээгээ биелүүлээгүй хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийг хөтөлбөрөөс хасуулах, хуулийн дагуу арга хэмжээ авах саналыг ҮХААЯ-д хүргүүлж шийдвэрлүүлнэ”,

⁹ “...Мах боловсруулах үйлдвэрлэл эрхлэн явуулж буй өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага нь ариун цэврийн шаардлага, тэдгээртэй холбогдон Монгол улсын мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хэрэгжүүлэх, түүнийг сахин биелүүлэх, дүрэмд заасан нөхцөлүүдийг хангах үүрэгтэй.”

¹⁰ Мал, амьтныг зөвхөн хяналтын эрх бүхий байцаагчийн зөвшөөрлөөр нядална.”

¹¹ “Хяналтын байцаагч нь бүх гулууз, боловсруулж буй махан бүтээгдэхүүнд нэг бүрчлэн үзлэг хийж, гулууз бүрт тусгай дугаар наана.”

хэмжээгээр нөөцөлсөн аж ахуйн нэгж, иргэдээс бэлтгэсэн махныхаа 83 хувийг худалдан авсан байна.

ҮХААЯ мал, мах бэлтгэлийн ажил дууссан 11 дүгээр сарын сүүлээр махны нөөц бэлтгэх гэрээг хэт орой байгуулсан нь 2013 оны хаврын хэрэгцээний махыг өндөр үнээр бэлтгэх нөхцөл болсон байна.

Агуулахад хүлээн авсан маханд нөөцийн махны сертификат бичигдэж нөөцийн махны менежер, зоорийн менежер, ОБЕГ, МХЕГ-ын төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Бэлтгэсэн маханд MNS 1111:2007 стандарт зөрчигдсөн, чанарын шаардлага хангаагүй, цээжний ба хэвлийн хөндийгөөс зарим дотор эрхтнийг салгаж аваагүй, чулуу, төмөр гэх мэт зүйлс гарсан гулууз мах ч байжээ.

Зоориудад хадгалагдаж буй бэлтгэсэн махны чанар, эрүүл ахуйн шаардлагын хангалттай 2013 оны 5 дугаар сарын 22-ны өдөр танилцахад Мах маркет ХХК-ийн 209 дүгээр агуулахад 3.8 тн 21.7 сая төгрөгийн эрүүл ахуйн болон хүнсний хэрэгцээ шаардлага хангахааргүй хонины гулууз махыг ялган хураасан байлаа.



Хэрэгцээ шаардлага хангаагүй 3.8 тн хонины мах

Дархан-Уул аймагт мах бэлтгэсэн Баатарууд тэнгэр ХХК Булган, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл аймгуудаас мал эмнэлэг ариун цэврийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамрагдсан, гарал үүслийн гэрчилгээтэй малыг бэлтгэсэн байна.

Дархан meat фүүдс ХХК орон нутагт брокер ажиллуулан үхрийг амьдын жингээр малчдаас худалдан авч тууварлан үйлдвэртээ нядалсан, харин богийг орон нутагт нь нядалж махыг тээвэрлэж ирсэн байна.

Орхон аймагт Эрдмийт ХХК мөн дээрх аймгуудаас махны нөөцийг бүрдүүлжээ.

Бэлтгэх үйл ажиллагаанд нөөцийн махны менежментийн гэрээний хавсралт 1.2, махны стандартын шаардлага MNS 5023:2001-ийн 3.5.3 дах заалтыг тус тус зөрчиж байна. Тухайлбал:

- Нядалгааны цехийн цэвэр хэсгийн технологийн дамжлагын урсгал зөрчигдөж гэдэсний агуулахуудаар гулууз дахин бохирдох нөхцөл үүсчээ.
- Нядалгааны цехийн хана, таазны будаг шохой хуурч унасан, гэрлийн бүрхүүл, гар хатаагчгүй, гар угаах цорго нь мэдрэгчгүй,
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчлага, холбогдох мэдээллийг самбар буюу ханан дээр бичиж байрлуулаагүй,
- Санхүүгийн тайланд үйл ажиллагааны орлого болон зардлыг бүрэн тусгаагүйгээс бэлтгэсэн махны нэгжийн өртөг тооцох боломжгүй,
- Махыг худалдахдаа нэгжийн үнээр, бусад үед тоо хэмжээгээр бүртгэл хөтөлж анхан шатны баримтаас эхлэн үнэн зөв илэрхийлээгүй байлаа.

Эрдмийт ХХК нийт нөөцөлсөн махыг 4 ширхэг сертификатад нэгтгэн бичиж орлого авсан байна.

Хадгалалтын явцад ажлын байрны нөхцөл, хөдөлмөр аюулгүй ажиллагааг сайжруулах шаардлагатай байна

Нийслэлд Жаст Агро ХХК-тай Зоорины менежментийн гэрээ байгуулсан 9 аж ахуйн нэгжүүдийн агуулахын байранд НМХГ-ын улсын байцаагчид “MNS 5364:2011 стандартын шаардлага хангаж байна” гэсэн дүгнэлтийг гаргажээ.

Мөн Дархан-Уул, Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчид Дархан Meat Фүүд ХХК-ийн 5000 тн, Эрдмийт ХХК-ийн 1000 тн, Мах маркет ХХК-ийн 300 тн-ын түрээсийн зоориудад цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал нь хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан, нөөцийн мах хадгалах боломжтой гэсэн дүгнэлт гаргасан ч хадгалах явцад махны хяналтын дүрмийн 4.8, 4.11, 21.2, Мах, махан бүтээгдэхүүн, эрүүл ахуйн аюулгүй байдлын үндсэн шаардлага MNS 5023:2001 стандартын 3.3.1, 3.3.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Тухайлбал:

- Аммиакан хөдөлгүүртэй хөргүүрийн цехийн техникийн ажилтнууд зориулалтын хөдөлмөр хамгааллын хувцас байдаг ч тогтмол өмсөж хэвшээгүй,
- Техникийн ажилтны хяналтын байр нь аммиакан хөдөлгүүрийн өрөөнөөс бүрэн тусгаарлагдаагүй, ажлын байрны аюулгүй ажиллагаа хангагдаагүй,
- Аммиакын хор уршиг, түүнээс хамгаалах аюулгүй ажиллагааны самбар байхгүй,
- Зоориноос махыг машинд ачих зогсоол болон зам хайрга, шороогоор байна

Нөөцийн мах хадгалж буй агуулах бүрийг хаягжуулан, агуулахад томилогдсон нягтлан бодогч, ОБЕГ, мэргэжлийн хяналтын байцаагчийн хяналтан дор нярав зарлага гаргадаг байна.

Ангилан савлах явцад доголдол гарч байжээ

Нөөцийн махыг Зоорийн менежментийн гэрээний 1.2-т зааснаар Зоорийн менежер нь хүлээн авч ангилан савлаж борлуулжээ.

Нөөцийн махны менежерийн зүгээс зоорины менежер аж ахуйн нэгжүүдийн удирдлага болон технологийн ажилчдыг хамруулан сургалт зохион байгуулж нөөцийн махыг жижиглэн савлах горим, технологийн заавар, гарын авлагыг хүргүүлсэн байна.

Ангилан савласан нөөцийн махыг тусад нь агуулахад хадгалж, орлогыг бүртгэн талуудын төлөөлөгч нар баталгаажуулж, тайланг долоо хоног бүр гаргасан байв.

Нөөцийн мах савлах уутыг нэгдсэн стандарттай болгох үүднээс ОБ Пластик ХХК-д шошго, тэмдэгтэйгээр захиалан бэлтгүүлж, зоорины менежер аж ахуйн нэгжүүдэд хуваарилсан байна.

Махны төрлөөр, савлах зохимжит хэмжээний стандарт байхгүй ч нийслэлд зоорины менежер аж ахуй нэгжүүд нөөцийн үхрийн махыг 2-10 кг-аар, хонь, ямааны махыг 1.5-2.5 кг, орон нутагт 2-3 кг-аар хөрөөдөн савлаж бэлтгэсэн бөгөөд зарим нэг уут махны 30-40 хувь нь ястай, орлого багатай иргэд савласан хэмжээгээр худалдан авч чадахгүй тохиолдол гарсан байна.

Мах маркет ХХК-ийн ангилан савлах цехийн өрөөний ханын шохой зарим хэсэгт хуурч унасан, ажилтнууд нь ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд ноосон бээлийтэй нөөцийн махыг савласан, Эрдмийт ХХК борлуулсан махны баглаа боодол дээр савласан огноог тавиагүй, сав, баглаа боодлын чанар муугаас урагдаж задарсан зэрэг зөрчлүүд гарсан байна.

Бэлтгэсэн нөөцийн махны ангилан савласны болон хорогдлын зардлыг илүү санхүүжүүлжээ

Нөөцийн махны менежер компаниуд 2013 оны хаврын хэрэгцээний 10.6 мян.тн нөөцийн махыг нийслэлд 9 дүүргийн Худалдаа, үйлчилгээний хэлтсийн баталсан 358 дэлгүүрээр, Орхон, Дархан-Уул аймагт 13-67 гэрээт цэгээр худалдан борлуулжээ.

Нийслэлд нөөцийн махны борлуулалт, худалдааг ард иргэдэд нээлттэй, мэдээллээр байнга хангах зорилгоор нөөцийн махны гэрээт борлуулагчдын хаяг байршил, борлуулсан нөөцийн махны мэдээллийг www.justgroup.mn, ҮХААЯ-ны www.mofa.mn сайтуудад байршуулж, өдөр тутмын “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонинуудад долоо хоног бүр мэдээлж, өргөтгөсөн худалдааны реклам, зар сурталчилгааг телевиз, FM, радио болон мэдээллийн вэб сайтуудад тавьж ажиллажээ.

ҮХААЯ жижиглэнгийн борлуулалтад хяналт тавиулахаар Нийслэлийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Монголын махны холбоо, Эрүүл мэнд аюулгүй байдал, Хүнс эвсэл зэрэг төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж ажилласан байна.

Нийслэлд нийт бэлтгэсэн нөөцийн махны 78.6 хувийг Хүчит шонхор, Нарантуул-2 захууд, өргөтгөсөн худалдаа явуулсан цэгүүдэд гулуузаар, 21.5 хувийг жижиглэн савлаж гэрээт борлуулагчдаар тус тус борлуулсан байна.

Нөөцийн махны менежерүүдтэй хийсэн нөөцийн махны менежментийн 4 талт болон ҮХААЯ-тай хийсэн санхүүжилтийн гэрээг 2013 оны 7 дугаар сарын 22-нд дүгнэж акт үйлдсэн байна.

Мөн Жаст Агро ХХК 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдөр 9 компанитай байгуулсан зоорийн менежерийн гэрээгээ дүгнэжээ.

Нөөцийн махны менежментийн гэрээний 5.2-т нөөцийн махны 1 кг тутамд жижиглэж, ангилан савлах зардлыг 80 төгрөгөөр тусгасан ба менежер компаниуд нийт бэлтгэсэн махны 18.6-78.6 хувийг буюу 7.4 мян.тн-ыг гулуузаар борлуулсан байхад 589.9 сая төгрөгийн ангилан савласны зардлыг дээрх гэрээний 5.5¹²-д заасныг мөрдөөгүй, СЯ, ҮХААЯ хяналгүйгээр илүү санхүүжүүлснийг дараах хүснэгтээр харуулав.

Нөөцийн махны менежер компаниуд	Бэлтгэсэн мах тн-р	Худалдан борлуулсан мах, тн-р					Илүү олгосон санхүүжилт /сая төгрөгөөр/
		нийт	гулуузаар		Ангилан савлаж		
			тоо	хувь	тоо	хувь	
Жаст-Агро	9 421.0	8 618.8	6 771.3	78.6	1 847.5	21.4	541.7
Баатарууд тэнгэр	1 000.0	1 000.0	186.1	18.6	813.9	81.4	14.9
Эрдмийт	1 000.0	1 000.0	416.2	41.6	583.8	58.4	33.3
Бүгд	11 421.0	10 618.8	7 373.6	69.4	3 245.2	30.6	589.9

¹² "...нөөцийн махыг жижиглэн худалдаанд нийлүүлж дууссаны дараа, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн гүйцэтгэгчид шилжүүлнэ"

Мөн хадгалсан маханд гүйцэтгэлээр 10.8 сая төгрөгийн хорогдлын зардлыг санхүүжүүлэх байтал нийт бэлтгэсэн 9.4 мян.тн махаар тооцож 2,108.9 сая төгрөгийг Жаст Агро ХХК-д илүү олгосон байна.

Зоорины менежментийн гэрээний 2.7.2¹³-т нөөцийн махыг дэлгүүрүүдэд 7 хоногт 2 удаа нийлүүлэхээр тусгасан нь хэрэгжээгүй, 325 дэлгүүр өөрсдийн унаагаар бэлэн мөнгөөр худалдан авсан ба зөвхөн Багануур, Налайх, Багахангай дүүргийн сүлжээ дэлгүүрүүдэд түгээлт хийжээ.

Нийслэлд нөөцийн махны чанар, үнэ, хүртээмжийн талаар БНД, НД, БХД, СБД, ЧД, БЗД, ХУД-дэд нөөцийн махны борлуулалт хийж буй 108 дэлгүүр, Хүчит шонхор, Баянзүрх зах, дэлгүүрийн удирдлага, худалдагч, иргэдтэй хийсэн ярилцлага, уулзалтаар дараах санал гарч байлаа. Үүнд:

ЧД-ийн “Ослер” ХХК-ийн хүнсний 1 дүгээр дэлгүүрийн захирал Б.Цэндсүрэн, нярав н.Жаргал:

- Нөөцийн мах худалдаалах явцад жингийн зөрүүгээс худалдагч нар дээр өр дутагдал гардаг,
- Тээврийн зардлаа өөрсдөө хариуцдаг,
- НӨАТ-ын падаан өгдөггүй,
- Мах савласан уутны чанар муу,

БЗД-ийн 3 дугаар хороонд байрлах Сансар супермаркетын зохион байгуулагч Д.Тэгшжаргал:

- Худалдан авагчид үхрийн махыг түлхүү авах хүсэлт тавьдаг,
- Савласан уут нь ачилтын явцад задарсан ирдэг,
- Өмнөх жилүүдтэй харьцуулахад үнэ өндөр байна гэсэн санал, гомдол их гардаг.

СБД-ийн “Мастер фүүдс” ХХК-ийн менежер М.Ууганцэцэг:

- Сав, баглаа боодол муутай амархан урагдаж задардаг,
- Үхрийн мах авахад ямаа заавал дагалдуулдаг,
- Ямааны махны борлуулалт муу байдаг.

ЧД-ийн “Эх булаг” ХХК-ийн хүнсний 4 дүгээр дэлгүүрийн худалдагч Янжиндулам:

- Махны чанарын талаар иргэдээс яс ихтэй, туранхай байна гэсэн санал их ирдэг,
- Мах ирсэн өдөр тооцоо зөрж, дутагдал гардаг,
- Савласан махны дотроос цус, элэг гарсныг буцааж өгсөн ч аваагүй.

Дэлгүүрүүдэд жижиглэн савлагдсан махны ихэнх уут урагдаж задарсан, дэлгүүр скочдож боосон байдал түгээмэл байв.

Мөн ихэнх дэлгүүрт нийлүүлэгдсэн ямааны махны чанар хангалтгүй байлаа.

Тухайн нутаг дэвсгэрт борлуулах нөөцийн махны хэмжээг оршин суугчдын тоотой уялдуулан тогтоогоогүй, бэлэн мөнгөөр худалдан авах санхүүгийн чадамжтай дэлгүүрүүдийг сонгосон байна.

ЧД-ийн Хүчит шонхор захын нөөцийн махны борлуулалтад 2013 оны 5 дугаар сарын 5, 23-ны өдөр аудитын баг ажиглалт хийхэд дараах байдалтай байв. Үүнд:

- 22-67 УБЛ, 32-70 УБ улсын дугаартай машинууд дээр борлуулагч нар баталгаажуулаагүй жингээр борлуулалт хийж байсан,
- 32-70 УБ дугаартай машин дээр борлуулалт хийж байсан борлуулагч н.Алтанзаяа: Өнөөдрийн ирсэн 2785 кг махан дотор хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй 8-9 кг жинтэй 18 ш гулууз мах ирснийг буцаалт хийхгүй ямар нэгэн байдлаар борлуулах шаардлага тавьсан гэж байлаа.

Нийслэлд Хүчит шонхор, Нарантуул-2 захуудаар 1 кг-ийг 5700 төгрөгөөр бөөнөөр борлуулсан махыг ченжүүд аваад эргээд иргэдэд 7200-7500 төгрөгөөр худалдаж байжээ.

¹³ “...Нөөцийн махыг дэлгүүрт хүргэх тээвэрлэлтийн үйл ажиллагааг Зоорины менежер нь өөрийн тээвэр болон тээврийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.”

Үүнээс харахад махны үнийг тогтворжуулан иргэдийг хямд үнэтэй махаар хангах хөтөлбөрийн зорилго бүрэн хангагдсан, олгосон хөнгөлттэй зээл, урамшуулал үр нөлөөтэй болсон гэж үзэхээргүй байна.

Мөн Орхон аймгийн иргэд зөвхөн хаврын улирлыг сонгож нийт махны хэрэгцээний 19 хувийг хямдралтай үнээр нийлүүлж байгаа нь цаг зуурын ажил төдийгүй махны үнэнд нөлөөлөхөөргүй байна гэж дүгнэжээ.

БҮЛЭГ 3**Хүн амыг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махаар тогтвортой хангах бодлого үгүйлэгдэж байна****Зөрчлийн дийлэнх нь бэлтгэл, борлуулалтын үед гарчээ**

Нийслэл, Орхон, Дархан-Уул аймагт нөөцийн махыг бэлтгэх, хадгалах, борлуулах үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагууд, ҮХААЯ, Жаст агро ХХК-ийн төлөөлөл оролцон “Улсын нөөцийн махны бүрдүүлэлт, борлуулалтад хяналт шалгалт хийх гэрээ” байгуулан ажилласан байна. Тухайлбал,

- Нийслэлд Нийслэлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Монголын махны холбоо, Эрүүл мэнд аюулгүй байдал, Хүнсний тусгаар байдлын төлөө хүмүүсийн эвсэл зэрэг төрийн бус байгууллагууд гэрээний хавсралтад заасан хуваарийн дагуу,
- Орхон аймагт ҮХААЯ болон ОБЕГ, МХЕГ, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээс,
- Дархан-Уул аймагт ҮХААЯ болон аймгийн МХЕГ, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс тус тус хяналт тавьж ажиллажээ.

Нөөцийн махны менежментийн гэрээнд МХЕГ нь улсын нөөцөд бэлтгэгдэж буй мах мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуй, чанарын шаардлага хангаж буй эсэхэд, ОБЕГ нь агуулахаас нөөцийн махыг жижиглэн худалдаанд нийлүүлж борлуулах үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт тавихаар, мөн зоорины менежментийн гэрээний 4.1-д “Зоорины менежерийн үйл ажиллагааны бүх шатанд “Хүнсний тухай хууль”, “Нөөцийн тухай хууль” тэдгээртэй холбогдуулан гаргасан эрх зүйн актууд болон НАССР-ийн (Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг хянах тогтолцоо) шаардлага, MNS 2457-2009, MNS 2456-2009, MNS 5023-2001 зэрэг стандартууд хангагдаж буй эсэхэд ОБЕГ, МХЕГ-тай хамтран хяналт тавьж ажиллах үүрэг хүлээхээр тус тус тусгажээ.

Нөөцийн махны менежментийн гэрээнд зааснаар мах бэлтгэлийн үед МХЕГ болон ОБЕГ-аас томилогдсон ажилтнууд зооринд мах хүлээн авах үед хяналт тавих явцад зарим хүндрэл гарчээ.

- Хөдөө орон нутагт хээрийн бойгоор бэлтгэсэн болон хувь иргэдээс шууд худалдан авч нийслэлд нийлүүлэгдсэн мах мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн чанарын шаардлага хангасан эсэхийг хянах боломжгүй.
- Нөөцөд бэлтгэгдэж байгаа махыг үүргийн худалдаа эрхлэгчдээс шууд худалдан авч хадгалах явцад мэргэжлийн байгууллага техник, тоног төхөөрөмжөөр дээж авч нарийн шинжилгээнд хамруулах боломжгүй.

Хяналтын явцад гарсан зөрчлийн дийлэнх нь бэлтгэл, борлуулалтын үед гарсан байна. Тухайлбал:

- нийслэлд эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаагүй 3.8 тн мах бэлтгэгдсэн,
- хувь хүн, ченжүүдээс авсан зарим махны чанар хангалтгүй,
- Хүчит шонхор зах дээр ченжүүд өөрсдөө борлуулж буй машин дээр гарч махыг шилж авч байсан,
- борлуулагч нар ариун цэврийн шаардлага хангаагүй хувцастай,
- нөөцийн махны үнийг ил тод бичиж тавиагүй, зарим махны үнийг дарж цаас наасан,
- баталгаажгаагүй жингээр борлуулалт хийж байсан,
- Орхон аймгийн нөөцийн махны худалдаалах төв цэг “Хүлэг хүнсний зах”-ын лангуу зориулалтын хөрөөгчгүй, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүйд албан шаардлага хүргүүлж зөрчлийг арилгуулсан,
- олгосон талоноор гулууз мах зарагдаж байгаад хийсэн хяналт шалгалтаар бичилт хийгдээгүй 8 ш талон илэрсэн,
- хүнсний захын махны ченжүүд талоноор 28-30 кг-тай махыг худалдан авсан зэрэг зөрчлүүд гарсан байна.

Мах бэлтгэх үйл явц орон нутагт харилцан адилгүй байгаа бөгөөд зарим газар сайн туршлага байна. Тухайлбал, Орхон аймагт мах бэлтгэсэн Эрдмийт ХХК өөрийн брокеруудыг хөдөө орон нутагт явуулан мал худалдан авч, намар нядлахаас өмнө эрүүл ахуйн шинжилгээг үхэр тус бүрт, хонь ямаанаас санамсаргүй байдлаар түүвэрлэн хийж, өөрийн итгэмжлэгдсэн лабораторид шалган үздэг байна.

Нөөцийн махны менежментийн 129 дүгээр гэрээний 5.2-т нөөцийн махыг бүрдүүлэх үйл ажиллагаатай холбогдсон хяналтын зардлыг 2013 оны 7 сарын 15-ны өдөр хүртэл 1 кг тутамд 15 төгрөг байхаар тогтоожээ.

Нийслэлд дээрх гэрээний 6.1, 6.3 дахь заалтыг үндэслэн нөөцийн махны борлуулалтын үйл ажиллагаа, борлуулж буй махны тоо хэмжээ, чанарт хөндлөнгийн хяналт хэрэгжүүлсэн 7 байгууллагад ажлын гүйцэтгэлээр 104.5 сая төгрөгийн хяналтын зардлыг олгосон байна.

Аудитын явцад агуулахуудаар явж танилцахад нөөцийн махны менежерээс болон ОБЕГ-аас томилогдсон хяналтын ажилтнууд, улсын нөөцийн нярав нар давхар хяналт тавьж машиныг битүүмжлэн лацдаж, борлуулах цэгт ирэхэд хөндлөнгийн хяналтын байгууллагын ажилтнууд шалган онгойлгож борлуулалтыг эхлүүлж байв.

Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махаар хангах шаардлагатай байна

Нийслэл, Орхон, Дархан-Уул аймагт 2012 оноос хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авч барагдуулах утас ажиллуулсан нь сайшаалтай ч нийт гарсан гомдолд дүн шинжилгээ хийж тодорхой арга хэмжээ авах ажил хангалтгүй байна.

Иргэдийн санал хүсэлт, аудитын явцад ажиглагдсан байдлаас харахад нөөцийн махны төрөл, хэмжээ, баглаа боодол, савлагааны хэмжээ нь иргэдийн худалдан авах чадавхиас шалтгаалан орон нутаг, дүүрэг хороодод өөр өөр байна.

Нөөцийн махыг худалдан борлуулж буй гэрээт дэлгүүрүүдэд хөргөлттэй агуулах хүрэлцээгүй, зориулалтын тээврийн хэрэгсэлгүйгээс тээвэрлэлтийн явцад махны уут урагдах, уутны амны битүүмжлэл алдагдах, гэрээ байгуулсан боловч татан авалт хийдэггүй, мах нийлүүлж буй байгууллагаас борлуулж буй махны савласан огноо тодорхойгүй, жижиглэж савласан мах нь яс ихтэй, хэтэрхий туранхай байгаа нь “Хүнсний тухай” хуулийн 10.1.2, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай” хуулийн 10.1.9 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Дээрх зөрчил дутагдлыг арилгуулахаар мэргэжлийн хяналтын байцаагч нар зориулалтын хөргөгч, хөргүүрээр хангах, нөөцийн махны ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах албан шаардлага, аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаа явуулж байсан цэгийг өөрчлөх саналыг хүргүүлэн “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай” хуулийн 14.1.2 дэх заалтын дагуу торгууль, шийтгэврийг ногдуулж барагдуулсан байна.

Нөөцийн махыг хүлээн авахдаа зэрэг дугаарын тамга дарж түүнийг дагалдуулсан мал эмнэлэг, ариун цэвэр гарал үүслийн гэрчилгээтэй болгож махны чанар, зэрэг дугаарыг харгалзан үнийг ялгавартай тогтоодог байх шаардлагатай байна.

Аудитын явцад авсан санал асуулгаар бэлтгэн нийлүүлж байгаа махны чанарыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултанд судалгаанд хамрагдагсдын таван хүн тутмын дөрөв нь чанарын шаардлага хангахгүй байна гэж хариулжээ.

Санал асуулгын дүнгээс нөөцийн махны хүрэлцээ хангамж бололцооны хэмжээнд байгаа боловч чанар төдийлөн сайнгүй, төрийн бодлого зохицуулалт байгаа ч үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна гэж үзэхээр байна.

Бэлтгэсэн нөөцийн мах хэрэгцээ шаардлага, мах бэлтгэлийн өртөг болон зах зээлд нийлүүлж буй үнэ зохистой, хадгалалт, борлуулалт үр дүнтэй байгаа эсэхэд хэрэглэгчийн үнэлгээ, судалгааг тогтмол хийж цаашдын стратегийг тодорхойлох үйл ажиллагаа дутагдалтай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Хүнсний аюулгүй байдал хөтөлбөрт тусгагдсан үйлдвэрийн аргаар 50.0 мян.тн мах бэлтгэх болон махны үйлдвэрлэлийн хэмжээг 2007 оноос 35 хувиар нэмэгдүүлэх, мөн 2013 оны хаврын улирлын махны үнийн өсөлтийг өмнөх оны мөн үеийнхээс 2 дахин бууруулах зэрэг ҮХАА-н салбарын тэргүүлэх зорилтууд бүрэн хэрэгжээгүй байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн зорилт нь Хүнсний тухай болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тухайн шатны Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах, хангамжийг сайжруулах заалттай зөрчилдөж байна.

Нийт бэлтгэсэн махны 69.4 хувийг гулуузаар борлуулсан байхад ангилан савласны, 99.5 хувь нь хорогдоогүй байхад хорогдлын зардалд 2,698.8 сая төгрөгийг илүү санхүүжүүлсэн байна.

Засгийн газраас махны ханган нийлүүлэлтийг сайжруулахаар баталсан “Загас” дэд хөтөлбөр, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд загас, гахай, тахианы аж ахуйг дэмжих, өндөр ашиг шимтэй махны чиглэлийн үржлийн өсвөр үхрийг импортлон цогцолбор аж ахуйг байгуулах, дотоодын зах зээлийг махны чиглэлийн хээлтэгч, хээлтүүлэгч, үрээр хангах зэрэг арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, үр дүн гарах болоогүй байна.

Хүн амын махны хэрэглээ, малын тоо, толгойн өсөлт, сүргийн бүтэц, нядлах боломжит малын зохистой харьцаа, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний тоо хэмжээ, зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн талаарх судалгаа, мэдээний үзүүлэлтээр мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх шаардлагатай байна.

Хүнсний аюулгүй байдал, хангамжийн статистикийн үзүүлэлт болон өрхийн хэрэглээний сагсыг тооцох аргачлалаар зах зээл дэх махны үнийн түүвэр судалгааг хийхдээ захуудын борлуулалтын хувь хэмжээг харгалздаггүй, шинэ махны үнийн арифметик дунджаар гаргаж нийтэд зарлан мэдээлдэг нь махны үнийг хөөрөгдөх, хэрэглэгчдийг төөрөгдүүлэх сөрөг үр дагавартай байна.

Нөөцийн мах хадгалах зарим зоорины хадгалалтын горим болон техник аюулгүй ажиллагаа доголдолтой, үйлдвэрт мөрдөх эрүүл ахуйн стандарт зөрчигдсэн байна.

Дархан-Уул, Орхон аймаг, Нийслэлийн 9 дүүргийн хэрэглэгчээс авсан судалгаа, санал асуулгад оролцогсдын гуравны хоёроос илүү нь мах бэлтгэн нөөцөлж борлуулах үйл ажиллагаа түүний хэрэгжилтэд сэтгэл дундуур, бэлтгэсэн махны чанар тааруу, төрийн бодлого, зохицуулалт дутагдалтайгаас махны ченж, бэлтгэн нийлүүлэгч компаниудын хуйвалдаантай холбоотойгоор зах зээлд махны үнэ буурахгүй байна гэж үзжээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад толилуулах нь:

Аймаг, нийслэлийн болон тухайн шатны Засаг дарга нарын Хүнсний тухай болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээний хэрэгжилтийг хангуулахад онцлон анхаарах.

Монголбанкны Ерөнхийлөгчид

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр”-ийн болон арилжааны банкуудтай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллах.

Үндэсний статистикийн хорооны даргад

Хүнсний аюулгүй байдал, хангамжийн статистикийн үзүүлэлт, өрхийн хэрэглээний сагсыг тооцох болон зах зээл дэх махны үнийн түүвэр судалгааны аргачлалыг хянан үзэж боловсронгуй болгох.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад

Мал аж ахуй, мах, махан бүтээгдэхүүний талаарх бодитой мэдээлэл, тоон үзүүлэлт бүхий мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах,

Малын тоо, толгойн өсөлт, сүргийн бүтэц, нядлах боломжит малын зохистой харьцаа, хүн амын махны хэрэгцээ, хэрэглээг судалсан бодитой мэдээлэлд тулгуурлан мах бэлтгэх, нийлүүлэх бодлогыг шинэчлэн боловсруулах арга хэмжээ авах,

Засгийн газраас махны ханган нийлүүлэлтийг сайжруулахаар баталсан хөтөлбөрүүдийн явц, үр дүнг тооцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх.



МОНГОЛ УЛСЫН
ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ЯАМ

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26-22-71, Факс: (976-11) 45-31-21,
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2014.01.03 № 01/33

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗРЫН МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР А.ЗАНГАД ТАНАА

Танай газраас “Нөөцийн мах бэлтгэх үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, саналаа боловсруулан хавсралтаар хүргүүлж байна.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА




Х.ЗОЛЖАРГАЛ

00000135

Жижиг албан бичиг 2013

2014 оны 1-р сарын 22-өдрийн 21/33
дугаартай албан тоотын хавсралт



НӨӨЦИЙН МАХ БЭЛТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН
ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ



Тайлбар 1

1. “Засгийн газрын 2013 оны 78 дугаар тогтоолын дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл байгуулагдаж, үйл ажиллагаа эхлээгүй” гэснийг “Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл” байгуулагдаж 2013 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр анхны хурлыг зохион байгуулсан. Тус хуралдаанаар Стратегийн хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын квотын талаар хэлэлцсэн. Мөн “Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл”-ийн орон тооны нарийн бичгийн даргыг томилон, ажиллаж эхлээд байна.

Тайлбар 2

2. “УХАА-н салбар хаврын улирлын махны үнийн өсөлтийг өмнөх оны мөн үеийнхээс 2 дахин бууруулах тэргүүлэх зорилт тавьсан нь хангагдаагүй” гэжээ. “Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн 2013 оны үр дүнг Монголбанкнаас тооцоолон гаргасан. Үүнд: Тус дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн хугацаанд буюу 2012 оны 10 дугаар сараас 2013 оны 7 дугаар сарын хооронд махны дундаж үнийн өсөлт өмнөх оны мөн үеэс 2 дахин бага байсан. Үхрийн цул махны үнийн жилийн өсөлт 2013 оны 7 дугаар сард өмнөх 5 жилийн дундаж өсөлтөөс 2.5 дахин бага, үхрийн ястай махны үнийн жилийн өсөлт 2.2 дахин бага, хонины махны үнийн жилийн өсөлт 3.4 дахин бага байсан (Зураг 1).

Зураг 1: Махны үнийн жилийн өсөлтийн хувь, 7 дугаар сард Зураг 2: Махны үнийн жилийн өсөлтийн хувь,



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Мах, махан бүтээгдэхүүний жилийн инфляцийн түвшин 2013 оны 7 дугаар сарын байдлаар 6.2 хувьтай байгаа нь өмнөх 5 жилийн дундаж өсөлтөөс 3.7 дахин бага байсан.

Тайлбар 3

3. “2011 оноос мөрдөж буй хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах тээвэрлэх харилцааг зохицуулах Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна” гэжээ.

- “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийг УИХ-аар 2011.06.02-нд батлуулж, 2012.06.01-нээс мөрдөж байна.

Засгийн газрын 2013 оны 30 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж” Төрийн өмчит хуулийн этгээд байгуулагдаж, Төрийн өмчийн хорооны 2013 оны 40 дүгээр тогтоолоор компаний дүрэм, бүтцийг батлан 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр үйл ажиллагааг эхлүүлсэн. “ХАА-н

бирж” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, 2013 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшин болон бизнес төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөг 100 хувь биелүүлж, татварт 233.6 сая төгрөгийн шимтгэл, Санхүүгийн Зохицуулах хороонд 243,8 сая төгрөг шимтгэл төлөөд байна.

ХААБ ХХК нь хуулиар олгогдсон чиг үүргийнхээ хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий 29 брокерт гишүүнчлэл олгож, 43 агуулах, 2 тээврийн компанид түр итгэмжлэл олгон арилжаанд оролцуулсан бөгөөд улсын итгэмжлэгдсэн лабораториудтай хамтран ажиллаж байна.

2013 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар 6382,1 тн ноолуур 385,2 тэрбум төгрөг, 1005 тн хонины ноос 1,5 тэрбум, 1048 тн тэмээний ноос 5,1 тэрбум, 14,912 тн тосны ургамал /рапс/-11,9 тэрбум нийт 403,6 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн.

2013 оны 03 сарын 07-ны өдрийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын А/35 тоот тушаалаар биржээр Хонины ноос, ноолуур арилжих тухай “Бараа, түүхий эдийн жагсаалт, ангилалын код”, “Бараа түүхий эдийг коджуулах журам”-ыг батлан, ҮХАА-н сайдын 2013 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/135 дугаар тушаалаар биржээр арилжих барааны жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, хүнсний буудай болон тосны ургамал /рапс/, малыг биржээр арилжих барааны жагсаалтад оруулан батлуулж, Малыг биржээр арилжихаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Тайлбар 4

4. 13 дугаар хуудасны доороос 17-19 дэх мөрөнд “...нөөц бүрдүүлэх хувь хэмжээнд өөрчлөлт оруулсан ч борлогдоогүй мах үлдсэнд тооцох хариуцлагын заалт гэрээнд алга байна” гэжээ. “Нөөцийн махны менежментийн 127, 128, 129 дүгээр гэрээний 3.10-т мах бэлтгэл, хадгалалт, худалдаалалтын үйл ажиллагаатай холбоотой учрах аливаа эрсдлийг тухайн компани бүрэн хариуцахаар заасан байгаа.

Тайлбар 5

5. 15 дугаар хуудасны дээрээс 7-9 дэх мөрөнд “Бэлтгэсэн маханд MNS 1111:2007 стандарт зөрчигдсөн, чанарын шаардлага хангаагүй, цээжний ба хэвлийн хөндийгөөс зарим дотор эрхтнийг салгаж аваагүй, чулуу, төмөр гэх мэт зүйлс гарсан гулууз мах байжээ” гэсэн нь бэлтгэсэн нийт махыг тодорхойлсон утгатай байгаа тул, энэхүү гомдол нийт махны хэдэн хувь, эсвэл гомдлын хэдэн хувиар илэрхийлбэл оновчтой байх.

Мөн хуудсанд “Орхон аймагт Эрдмийг ХХК мөн дээрх аймгуудаас бэлтгэсэн махыг зах зээлээс худалдан авч нөөцийг бүрдүүлжээ” гэж бичсэн хирнээ 20 дугаар хуудасны эхний мөрөнд “...сайн туршлага болгож, Орхон аймагт мах бэлтгэсэн Эрдмийг ХХК өөрийн брокеруудыг хөдөө орон нутагт явуулан мал худалдан авч, намар нядлахаас өмнө эрүүл ахуйн шинжилгээг үхэр тус бүрт, хонь ямаанаас санамсаргүй байдлаар түүвэрлэн хийж, өөрийн итгэмжлэгдсэн лабораторид шалган үздэг байна” гэжээ. Тухайн компанийн хувьд нийт бэлтгэсэн үхрийн махыг 100 хувь, хонь, ямааны 20 гаруй хувийг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн.

Тайлбар 6

Дүгнэлтийн хэсэгт: “Сангийн яам болон ҮХААЯ махны нөөцийн үйл ажиллагаанд тавих хяналтын үүргээ хэрэгжүүлээгүй, нийт бэлтгэсэн махны 69,4 хувийг гулуузаар борлуулсан байхад ангилан савласны, 99,5 хувь нь хорогдоогүй байхад хорогдлын зардалд 2,698.8 сая төгрөгийг илүү санхүүжүүлжээ” гэсэнд тайлбар гаргах нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 47 дугаар тэмдэглэлийн 2.1-т “Хүн амын 2013 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан 16 мянган тонн мах бэлтгэн нөөцлөх, худалдан борлуулах ажлыг хариуцан зохион байгуулахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, нөөцийн мах бэлтгэсэн урамшуулалд зориулан 16.0 тэрбум

төгрөгийг орон нутгийн төсөвт тусган, санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Улаан нарт тус тус даалгав” гэж заасан.

2. Мөн Сангийн сайд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан 2013 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн “Нөөцийн махны урамшууллын хэмжээг тогтоох тухай” 100/А/70 дугаартай тушаалын 1-т “Хүн амын 2013 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан бэлтгэн нөөцөлж, худалдан борлуулсан махны нэг килограмм тутамд олгох урамшууллын хэмжээг 1000 (нэг мянга) төгрөгөөр тооцсугай” гэж заасан байгаа.

3. Нөөцийн махны менежментийн гэрээний 5.2-т нөөцийн махыг бүрдүүлэх үйл ажиллагаатай холбогдсон зардлыг 1 кг тутамд тооцоход нөөцийн мах хадгалах агуулахын түрээсийн төлбөр нь 550 төгрөг, мах хүлээн авах, ачилтын зардал 15 төгрөг, жижиглэж, ангилан савлах зардал 80 төгрөг, сав баглаа боодлын зардал 55 төгрөг, түгээлт, тээврийн хэрэгслэлийн зардал 60 төгрөг, хорогдлын зардал 225 төгрөг, хөндлөнгийн зардал 15 төгрөг гэж заасан.

Гэвч нөөцийн махны зорийн менежер компаниудад олгох үйл ажиллагааны урамшууллын санхүүжилт хоцорч байсан учраас ажилчдын цалин, агуулахын ашиглалтын зардал, зээлийн хүү, зээл төлөлт гэх мэт бусад зардлуудыг санхүүжүүлэхэд хүндрэлүүд үүсч байсан. Үүний улмаас нөөцийн махны зорины менежер компаниуд санхүүжилтийн өөр эх үүсвэр олж үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байсан болно. Үүнтэй холбоотойгоор хугацаа хоцорсон хоног тутамд арилжааны банкны хамгийн бага зээлийн хүүгээр тооцоход 2,5 тэрбум төгрөгийн нэмэлт зардал төлсөн байх тооцоо байсан.

Мөн зарим компаниуд нь долларын зээлтэй байсан бөгөөд урамшууллын төлбөрийг хугацаандаа төлөөгүйн улмаас валютын ханшийн алдагдалд орж байсан.

Иймд дээрх байдлыг харгалзан үзэж бодит гүйцэтгэлээр тооцох зарим зардлыг нийт бэлтгэсэн махны хэмжээгээр тооцож олгосон.

Харин “Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд хөнгөлттэй зээлийн талаарх саналыг Монголбанкнаас авах нь зүйтэй юм.

-----000-----

Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар

Тайлбар 1. Тайланд тусгав.

Тайлбар 2. Монголбанкнаас гаргасан мэдээллэл тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлбар 3. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг баталсан огноогоор тайланд тусгалаа.

Тайлбар 4. Тайланд тусгав.

Тайлбар 5. Тайланд тусгав.

Тайлбар 6. Эрх зүйн баримт бичгийг тайланд дурдсан тул тайлбарыг хүлээн авах шаардлагагүй гэж үзлээ.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2014 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:


1. Нөөцийн мах бэлтгэн, нөөцөлж борлуулах үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Үндэсний статистикийн хороо, Монголбанкинд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2014 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч нарт зөвлөсүгэй.


4. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Ерөнхий аудиторын зөвлөлд танилцуулж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал /Б.Баттуяа/-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

tushaal-2013



Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014
оны 2 дугаар сарын 10-ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

/сая төгрөг/					
д/д	Агуулга	Хариуцах албан тушаалтан	Биелэлтийг ирүүлэх хугацаа	Дүн	Хариуцан барагдуулах
1	Илүү олгосон урамшууллыг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх тухай	Сангийн сайд Ч.Улаан, ҮХАА-н сайд Х.Баттулга	2014.07.01	2,698.8	Ахлах аудитор У.Баярмаа